

ТӨМӨР ЗАМЫН БАЙГУУЛЛАГЫН АЖИЛТАНД ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЗЛЭГ ХИЙХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Энэхүү журмаар Төмөр замын байгууллагын галт тэрэгний ба сэлгээний хөдөлгөөнтэй шууд холбоотой болон шууд бус холбоотой ажилтнууд, шинээр ажилд орох иргэн урьдчилсан ба хугацаат эрүүл мэндийн үзлэгт хамруулах харилцааг зохицуулах бөгөөд өмчийн хэлбэр харгалзалгүй төмөр замын бүх байгууллага дагаж мөрдөнө.
- 1.2. Эрүүл мэндийн үзлэг /цаашид үзлэг гэх/-ийг Галт тэрэгний ба сэлгээний хөдөлгөөнтэй шууд холбоотой болон шууд бус холбоотой ажилтнууд, шинээр ажилд орох иргэн эрүүл мэндээр тэнцэх эсэхийг тогтоох, галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй ажиллагааг хангах, мэргэжлээс шалтгаалах өвчин үүсэхээс сэргийлэх зорилгоор хийнэ.
- 1.3. Эрүүл мэндийн урьдчилсан ба хугацаат үзлэгийг ажилтнуудад 8-аас доошгүй чиглэлээр, клиник лабораторид цусны ерөнхий шинжилгээ, шээсний ерөнхий шинжилгээ, элэг, цөсний үйл ажиллагаа, элэгний В, С вирус илрүүлэх шинжилгээ, ХДХВ/БЗДХ илрүүлэх шинжилгээ, зүрхний цахилгаан бичлэг хийлгэх зэргээр амбулаториор зохион байгуулна.
- 1.4. Ажил мэргэжлээс шалтгаалж нэмэлтээр нарийн мэргэжлийн эмчийн үзлэг, лаборатори, үйл оношийн шинжилгээг явуулна.
- 1.5. Эрүүл мэндийн үзлэгийн эмч нарын багт дотор, мэдрэл, нүд, чих хамар хоолой, мэс засал, арьс, БЗДХ, сэтгэц, эмэгтэйчүүд, рентген, хөдөлгөөн засалч, мэргэжлээс шалтгаалах өвчний эмч нар байна.
- 1.6. Төмөр замын асуудал эрхэлсэн Төрийн захиргааны байгууллагын даргын тушаалаар батлагдсан Эмнэлэг хяналтын комисс /цаашид ЭХК гэх/ үзлэгийг зохион байгуулж явуулна.
- 1.7. Энэ журмын 1.6 дахь хэсэгт заасан ЭХК-ын бүрэлдэхүүнийг мэргэжлийн эмч, ажилчдыг оролцуулан томилох ба уг комисс нь Төмөр замын байгууллагын ажилтныг тухайн ажлын байранд тэнцэх эсэхийг тогтоох эрх бүхий этгээд мөн.
- 1.8. Төмөр замын байгууллагын ажилтныг эрхэлж буй ажлаар нь галт тэрэгний хөдөлгөөнтэй шууд болон шууд бус холбоотой ажилтан гэж хоёр ангилна.
- 1.9. Үзлэгт орох галт тэрэгний болон сэлгээний хөдөлгөөнтэй шууд холбоотой ажилтныг эрхэлж буй ажлаар нь дараах байдлаар ангилна:
 - 1.9.1. Хөдлөх бүрэлдэхүүн жолоодох,
 - 1.9.2. Хөдөлгөөн зохицуулалтын,
 - 1.9.3. Сэлгээний болон үзлэг засварын,
 - 1.9.4. Ачааны болон зорчигчийн галт тэрэгний ажиллагсдын,

- 1.9.5. Замын ,
 - 1.9.6. Холбоо, дохиолол төвлөрүүлэлт, хориглолт, эрчим хүчний.
- 1.10. Хөдөлгөөнтэй шууд бус холбоотой ажил мэргэжлийн ажилтныг эрхэлж буй ажлаар нь дараах байдлаар ангилна.
- 1.10.1. Удирдах ажилтан,
 - 1.10.2. Эмнэлгийн,
 - 1.10.3. Хүүхдийн,
 - 1.10.4. Цагдаагийн,
 - 1.10.5. Цэрэгжүүлсэн хамгаалалтын,
 - 1.10.6. Барилга орон сууцны,
 - 1.10.7. Соёл урлаг, спортын,
 - 1.10.8. Хүнс, нийтийн хоолны,
 - 1.10.9. Зочид буудал, амрах байр, үйлчлэгчийн,
 - 1.10.10. Тээврийн хэрэгслийн жолооч, хүнд оврын тээврийн хэрэгслийн жолооч, ажилтнууд,
 - 1.10.11. Засварын,
 - 1.10.12. Бусад.
- 1.11. Энэ журмын 1.9-д дурдсан ажил, мэргэжлийн ажилтан нь жилд 1 удаа / 50-аас дээш насны ажилтан 2 удаа/, 1.10-д заасан ажил мэргэжлийн ажилтан нь 2 жилд 1 удаа урьдчилан сэргийлэх үзлэгт орж, эрхэлж буй ажилд эрүүл мэндээр тэнцэх эсэх талаар ЭХК-ын дүгнэлт гаргуулсан байна. ЭХК нь үзлэгийн дүнг үндэслэн ажилтны дараачийн үзлэгт орох хугацааг тодорхойлж богиносгож болно.
- 1.12. Төмөр замын мэргэжлийн /гадаадын ба дотоодын/ сургууль, курст элсэж, цаашид галт тэрэгний ба сэлгээний хөдөлгөөнд шууд холбоотой ажил гүйцэтгэх суралцагч нь хичээл, дадлага эхлэхээс өмнө урьдчилсан үзлэгт орох ба төгссөний дараа уг ажилд эрүүл мэндийн хувьд тэнцэх эсэх талаар ЭХК-ын дүгнэлт гаргуулсан байна.
- 1.13. Эрүүл мэндийн хугацаат бус үзлэгийг дараах тохиолдолд хийнэ. Үүнд:
- 1.13.1. Нэмэлт шаардлага тавигдах өөр албан тушаалд шилжих буюу галт тэрэгний болон сэлгээний хөдөлгөөнтэй шууд холбоотой ажил хавсарч ажиллах,

- 1.13.2. Эрүүл мэндэд нь өөрчлөлт орсон гэж үзсэн ажилтныг байгууллага болон эмч нарын хүсэлт, шаардлагаар,
- 1.13.3. Ажилтан өөрөө, албан үүргээ гүйцэтгэхэд саад болох өөрчлөлт эрүүл мэндэд нь гарсныг мэдрээд үзлэгт орохыг хүсвэл,
- 1.13.4. Ажилтан болон ажил олгогчийн хооронд тухайн ажилтныг эрхэлж буй албан тушаалдаа эрүүл мэндээр тэнцэж байгаа эсэх талаар маргаан үүсэж, хүсэлт гаргавал.

Хоёр. Галт тэрэгний болон сэлгээний хөдөлгөөнтэй шууд холбоотой ажилтны аяллын болон ээлжийн ажлын өмнөх ба дараах эрүүл мэндийн үзлэгийг зохион байгуулах, бүртгэх, хяналт тавих

- 2.1 Галт тэрэгний болон сэлгээний хөдөлгөөнтэй шууд холбоотой ажилтнуудыг дараах чиглэлийн үзлэгт оруулна. Үүнд:
- ээлжийн ажлын өмнөх болон дараах,
 - аялалд гарахын өмнөх болон дараах.
- 2.2 Дараах ажлын байранд ажиллах ажилтныг ээлжийн ажлын өмнө үзлэг хийнэ. Үүнд:
- Галт тэрэгний ахлах диспетчер,
 - Галт тэрэгний диспетчер,
 - Өртөөний жижүүр,
 - Галт тэрэгний найруулагч,
 - Галт тэрэгний туслах найруулагч,
 - Вагон үзэгч.
- 2.3 Дараах ажлын байранд ажиллах ажилтныг аяллын өмнө болон дараа үзлэг хийнэ. Үүнд:
- Зүтгүүрийн машинч,
 - Зүтгүүрийн туслах машинч,
 - Сэлгээний машинч,
 - Сэлгээний туслах машинч,
 - Өөрөө явагч хөдлөх бүрэлдэхүүний машинч,
 - Өөрөө явагч хөдлөх бүрэлдэхүүний туслах машинч.

- 2.4 Галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй байдлыг ханган, осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор энэхүү журмын 2.2, 2.3 дахь хэсэгт заасан ажилчдад Эрүүл мэндийн болон Хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүдийн хамтарсан тушаалаар баталдаг согтууруулах ундааны зүйл, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн эсэхийг тогтмол шалгана.
- 2.5 Суурь бүтэц дамнан ажиллах ажилтны аяллын өмнөх болон дараах эрүүл мэндийн үзлэг хийх байршил, хяналтыг суурь бүтэц эзэмшигч нар харилцан тохиролцоно.

Гурав. Эрүүл мэндийн үзлэг явуулахад аж ахуйн нэгж, байгууллагын хүлээх үүрэг

- 3.1 Эрүүл мэндийн үзлэг явуулахад аж ахуйн нэгж, байгууллага дараах үүрэг хүлээнэ. Үүнд:
 - 3.2 Тухайн жилд өөрийн байгууллагын галт тэрэг, сэлгээний хөдөлгөөнтэй шууд холбоотой болон холбоогүй ажилтны эрүүл мэндийн үзлэгт орох нэрсийн жагсаалтыг овог нэр, нас, хүйс, албан тушаалаар ангилан гаргаж, 12 дугаар сарын 15-ны дотор ЭХК-д ирүүлнэ.
 - 3.2.1 Аж ахуйн нэгж нь ЭХК-оос гаргасан хуваарийн дагуу тухайн жилд эрүүл мэндийн үзлэгт орох ажилтныг бүрэн хамруулна.
 - 3.2.2 Үзлэгт орохоор явах ажилтны замын зардлыг аж ахуйн нэгж байгууллага хариуцна. Харин ажилд шинээр орох иргэн хувийн зардлаар явна.
 - 3.2.3 Үзлэгт орох ажилтныг цээж зураг бүхий, байгууллагын тамга дарж, асуултын дагуу бүрэн хөтөлсөн эмнэлгийн үзлэгийн хуудас, ажлын газрын үнэмлэхтэй явуулах ба байгууллагын хүний нөөцийн ажилтан үзлэгт хяналт тавьж оролцож болно.
 - 3.2.4 Ажил мэргэжлээс хамааран эрүүл мэндийн нэмэлт үзлэг, шинжилгээ хийх жагсаалтын (хавсралт-5) кодын дугаарыг Эрүүл мэндийн хугацаат үзлэгийн хуудасны кодын “№” хэсэгт тавьж илгээнэ.
 - 3.2.5 Ажилтны ажлын нөхцөл өөрчлөгдөх, эрхлэх ажилд эрүүл мэндээр тэнцэх эсэхэд эргэлзээтэй тохиолдолд шалтгааныг тодорхой заан ЭХК-д явуулж хугацаат бус үзлэгт оруулна.
 - 3.2.6 Галт тэрэгний ба сэлгээний хөдөлгөөнтэй шууд холбоотой ажилд тэнцэхгүй гэсэн ЭХК-ын дүгнэлт гарсан ажилтанд галт тэрэгний болон сэлгээний хөдөлгөөний бус ажилд шилжүүлэх арга хэмжээ авна.
 - 3.2.7 Үзлэгээр тухайн ажилд эрүүл мэндээр тэнцэхгүй гэсэн дүгнэлт гарсан буюу үзлэгт ороогүй ажилтныг ажилд гаргахыг хориглоно.
 - 3.2.8 Онош тодруулах, эмчилгээ хийлгэх шаардлагатай гэсэн ЭХК-ын дүгнэлт гарсан ажилтныг заасан хугацаанд нь явуулж шийдвэрлүүлэх үүргийг хүлээнэ.

- 3.2.9 Үзлэгээр харааны шил зүүж ажиллах шаардлага тавигдсан ажилтныг ажилдаа шилээ зүүж буй эсэхэд хяналт тавина.
- 3.2.10 Архаг хууч өвчтэй, өрхийн, үйлдвэрийн, нарийн мэргэжлийн эмч нарын диспансерын хяналтад байдаг ажилтныг эрүүлжүүлэх, чийрэгжүүлэх ажлыг дэмжиж оролцоно.
- 3.2.11 Ажилтныхаа эрүүл мэндийг хамгаалах, эрүүлжүүлэх, чийрэгжүүлэх, мэргэжлээс шалтгаалах өвчин, хурц хордлогоос урьдчилан сэргийлэх ажлыг хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн жилийн төлөвлөгөөнд тусган, санхүүжүүлж хэрэгжүүлнэ.
- 3.2.12 Ажилтны хөдөлмөрийн чадвар түр алдсан өвчлөлийг зохих маягтаар бүрэн бүртгэж, харьцуулсан судалгаа, дүгнэлттэй байна.
- 3.2.13 Өвчлөлийн судалгаа гаргаж жил бүрийн өвчлөл бууруулах төлөвлөгөө гаргаж эрүүл мэндийн байгууллагатай хамтран хэрэгжүүлнэ.
- 3.2.14 Ажилтнаас бие бялдар чийрэгжүүлэлтийн сорилыг ажлын байран дээр авч, үнэлгээг эрүүл мэндийн хуудасны хавсралт 5 дахь загварын дагуу гаргана.
- 3.2.15 Ажилтны бие бялдрын чанарын түвшинг сайжруулах дасгал хөдөлгөөнийг хувь хүний биеийн онцлогт тохируулан уян хатан, хурд, тэсвэр, авхаалж самбаа, тэнцвэрийн чанаруудын үзүүлэлтээр үнэлнэ.

Дөрөв. Үйлдвэрийн эмчийн хүлээх үүрэг

- 4.1 Үйлдвэрийн эмч дараахь үүрэг хүлээнэ. Үүнд:
- 4.1.1 Харьяа байгууллагын ажилтныг үзлэгт ороход амбулаторийн картанд түрүүчийн үзлэгээс хойших хугацаанд өвчилсөн өвчин, биеийн байдлын талаар дүгнэлт бичиж, шаардлагатай шинжилгээг хийлгэн, онцгой тохиолдолд үзлэгт биечлэн оролцож танилцуулах,
- 4.1.2 Үзлэгээр тухайн ажилдаа “Тэнцэхгүй” гэсэн дүгнэлт гарсан, онош тодруулах, эмчлүүлэх, хугацаа заасан заалттай болон өрхийн, үйлдвэрийн, нарийн мэргэжлийн эмчийн диспансерын хяналтад байх ажилтны талаарх мэдээллийг тухайн аж ахуйн нэгжийн хүний нөөцийн ажилтанд нь өгч, холбоотой ажиллах,
- 4.1.3 Үзлэгээр илэрсэн өвчин, нарийн мэргэжлийн эмч нарын заалтыг амбулаторийн картанд тэмдэглэн хэрэгжүүлэх,
- 4.1.4 Нарийн мэргэжлийн эмч нарын үзлэгээр илэрсэн өвчтөнийг диспансерийн хяналтанд авч эрүүлжүүлэх ажлыг төлөвлөгөөтэйгөөр хэрэгжүүлж, үр дүнг тооцож ажиллах,
- 4.1.5 Эрүүл мэндийн хугацаат үзлэгийн хооронд ажилтны өвчилсөн өвчин, эрүүл мэндэд гарсан өөрчлөлтийг илрүүлж, шаардлагатай тохиолдолд хугацаат бус үзлэгт оруулах,

- 4.1.6 Үйлдвэрийн ажилтнуудын дунд эрүүл мэндийн сургалт сурталчилгааг график, төлөвлөгөөтэйгөөр зохион байгуулах,
- 4.1.7 Үйлдвэрийн ажиллагсдын хөдөлмөрийн чадвар түр алдах өвчлөлийг сүүлийн 5 жилээр харьцуулсан судалгаатай ажиллаж, аж ахуйн нэгжийн захиргаанд ажилтны эрүүл мэндийг сайжруулах, хөдөлмөрлөх таатай нөхцөлийг бүрдүүлэх талаар саналаа боловсруулан өгч, хамтарч хэрэгжүүлэх.

Тав. Эрүүл мэндийн үзлэгт орох ажилтны хүлээх үүрэг

- 5.1 Эрүүл мэндийн үзлэгт орох ажилтны дараах үүрэг хүлээнэ:
 - 5.1.1 Үзлэгт заасан хугацаанд орох,
 - 5.1.2 Үзлэгт орохдоо эмнэлгийн үзлэгийн хуудас /зураг, тамгатай, асуултыг бүрэн хөтөлсөн/, ажлын газрын үнэмлэх, амбулаторийн карт, машинч, туслах машинч нар аяллын үзлэгийн хувийн карт, суралцагсад оюутны үнэмлэх зэргийг авч ирэх,
 - 5.1.3 Үзлэгт орсны дараа эмнэлгийн үзлэгийн хуудсыг аж ахуйн нэгжийн хүний нөөцийн ажилтанд, амбулаторийн картыг өрхийн буюу үйлдвэрийн эмчид бүрэн бүтэн хүлээлгэж өгөх,
 - 5.1.4 Үзлэгт орохдоо өөрт байгаа зовиур шаналгаа, өвчилсөн өвчин, хийлгэсэн эмчилгээ, биеийн байдлын талаарх мэдээллийг үнэн зөв өгөх,
 - 5.1.5 Өрхийн, үйлдвэрийн болон нарийн мэргэжлийн эмчийн диспансерын хяналтад байх заалттай ажилтан эмч нарын эмчлэн эрүүлжүүлэх талаар өгсөн зөвлөгөөг нэг бүрчлэн биелүүлж, өөрийн эрүүл мэндээ сайжруулахад санаачилгатай хандах,
 - 5.1.6 Хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр үзлэгээс хоцорсон ажилтан өөрийн зардлаар явж үзлэгт орох,
 - 5.1.7 Нүдний эмчийн үзлэгээр харааны шил зүүж ажиллах заалттай ажилтан эмчийн заавраар нүдний шилээ сайтар тааруулан 2 ээлжийн шилтэй байж, байнга зүүж ажиллах,
 - 5.1.8 Шинээр ажилд орж байгаа ажилтан болон оюутан суралцагсад нь үзлэгт орохдоо харьяалагдаж байсан өрхийн эмнэлгээс өвчилж байсан өвчин, биеийн байдлын талаарх бичлэгтэй амбулаторийн картыг авчрах.

Зургаа. Эмнэлэг хяналтын комиссын хүлээх үүрэг

- 6.1 Эмнэлэг хяналтын комисс дараах үүрэг хүлээнэ. Үүнд:
 - 6.1.1 Аж ахуйн нэгж, байгууллагын ажилтнуудын эрүүл мэндийн үзлэгт орох хуваарийг жил бүрийн 1 дүгээр сарын 15-ны дотор гаргаж хүргүүлэх,

- 6.1.2 Төмөр замын байгууллагуудад үзлэгт хамрагдах мэдээллийг 7-оос доошгүй хоногийн өмнө мэдэгдэх,
- 6.1.3 ЭХК нь “Галт тэрэгний ба сэлгээний хөдөлгөөнтэй шууд холбоотой ажилд хориглох заалттай болон харшлах өвчний жагсаалт”-ыг баримтлах бөгөөд өвчин бүрийг нарийвчлан авч үзэж, жагсаалтад байхгүй тохиолдолд адил төстэй өвчний заалтад хамааруулах,
- 6.1.4 Хугацаат үзлэгт орвол зохих, орсон, урьдчилсан болон хугацаат бус үзлэгт орсон, эрхэлж буй ажилдаа тэнцэхгүй дүгнэлттэй гарсан, хөдөлмөр зохицуулалт хийгдсэн /группэд орсон/, мэргэжлээс шалтгаалах өвчин, хурц хордлого илэрсэн зэрэг үзүүлэлтүүдээр жилийн эцэст тайлан гаргах,
- 6.1.5 Үзлэг явуулж дүгнэлт гаргахад зайлшгүй шаардлагатай багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангуулж ажиллах ба оношлогоонд зайлшгүй шаардлагатай үзлэг, шинжилгээг лавлагаа шатлалын эмнэлгүүдэд гэрээгээр хийлгэх,
- 6.1.6 Үзлэгийг журмын дагуу хийгээгүй комиссын гишүүнд захиргааны болон ёс зүйн арга хэмжээ ногдуулахаар зохих байгууллагад тавих.

---oOo---

Галт тэрэгний ба сэлгээний хөдөлгөөнтэй шууд холбоотой ажил, албан тушаал гүйцэтгэхэд хориглох өвчний жагсаалт

Нэг. Дотрын өвчин

1.1 Зүрх судасны эмгэг

- 1.1.1 Хэм алдалт. Пароксизмал тахикарди, тосгуур ховдлын хориг 1,2-р зэрэг, синусын зангилааны сулралын хам шинж, тосгуурын жирвэгнэл бусад хүнд хэлбэрийн хэм алдалтууд,
- 1.1.2 Зүрхний архаг дутагдал. Зүрхний архаг дутагдлын В,С шатанд хүргэсэн дараах эмгэгүүд: Атеросклероз, зүрхний шигдээс, кардиомиопати, артерийн даралт ихсэлт, зүрхний төрөлхийн ба олдмол гажиг, үрэвслийн болон дааврын шалтгаант зүрхний эмгэгүүд,
- 1.1.3 Зүрхний цус хомсрох өвчин. Ачаалалтай шинжилгээгээр онош батлагдсан, ТСДЭ хийх шаардлагатай,
- 1.1.4 Зүрхний шигдээс,
- 1.1.5 Артерийн даралт ихсэлт. Артерийн даралт ихсэлтийн 2-р зэрэг, бай эрхтний гэмтэл үүссэн,
- 1.1.6 Гол судас том салааны цүлхэн,
- 1.1.7 Захын судасны эмгэг. Гүний судасны эмгэг нь босох суух, өргөх, түлхэх зэрэг ажил хөдөлмөртэй холбоотой үйл ажиллагааны алдагдал үүсгэсэн.

1.2 Амьсгалын эрхтний эмгэг

- 1.2.1 Гуурсан хоолойн архаг бөглөрөлт өвчин, гуурсан хоолой тэлэгдэх өвчин, гуурсан хоолойн багтраа өвчний улмаас амьсгалын дутагдал илэрсэн /FEV1- 70%</,
- 1.2.2 Уушигны амьсгалах талбайг хязгаарласан эмгэгүүд. Уушигны фиброз, уушиг шалчийх, цээжний хэнхэрцгийн деформаци, фиброторакс,
- 1.2.3 Агаар дамжуулах замын эмгэгүүд.

1.3 Хоол боловсруулах эрхтэний эмгэг

- 1.3.1 Бүдүүн гэдэсний шархлаа, Кроны өвчин, ходоод 12 хуруу гэдэсний том хэмжээний шарх цус алдалтаар хүндэрсэн,
- 1.3.2 Цөс, нойр булчирхай, цөсний сувгийн хүнд хэлбэрийн өвчний үлдэц өөрчлөлт,

1.3.3 В, Дельта вирусийн шалтгаант элэгний архаг үрэвсэл,

1.3.4 Элэгний цирроз Чайльд Пьюгийн ангиллаар А шат.

1.4 Бөөр шээсний замын эмгэг

1.4.1 Бөөрний архаг дутагдлаар хүндэрсэн бөөр, шээс дамжуулах замын эмгэгүүд.

1.5 Дотоод шүүрлийн эмгэг

1.5.1 Чихрийн шижин 1-р хэв шинж, том жижиг судасны хүндрэл үүссэн чихрийн шижин 2-р хэв шинж,

1.5.2 Тархмал хордлогот бахуу дунд зэргийн хордлоготой, нүд болон зүрхний өөрчлөлт илэрсэн, мэс заслын дараах хүндрэл өгсөн,

1.5.3 Бамбайн дутагдал нь хүндрэл өгсөн,

1.5.4 Өнчин тархи, бөөрний дээд булчирхай болон дотоод шүүрлийн бусад эмгэгүүд.

1.6 Холбогч эдийн эмгэг

1.6.1 Тогтолцооны улаан чонон яр, тогтолцооны хатуурал ревматоид артрит, васкулит, дерматомиозит, полимиозит, Рейно хам шинж болон бусад яс үе, булчин шөрмөс зөөлөн эдийн эмгэгүүд нь хөдөлгөөний үйл ажиллагааг 2-оос дээш зэргээр алдагдуулсан.

1.7 Цусны эмгэг

1.7.1 Хүнд хэлбэрийн цус багадалт, цусны хоргүй хавдрууд.

Хоёр. Мэдрэлийн өвчин

2.1 Ухаан алдалтын бүх хэлбэрүүд, уналт таталт, уналт таталт төст хам шинжүүд,

2.2 Мэдэгдэхүйц мэдрэлийн өөрчлөлтүүд, бие хүн өөрчлөгдөх бэлгийн гаж өөрчлөлтүүд, ээрэх, эргэх маягийн үүрэг хийхэд саад болдог хөдөлгөөнүүд, нойрны өөрчлөлтүүд,

2.3 Төв мэдрэлийн системийн голомтот өөрчлөлт өгдөг тархины судасны өвчнүүд, тархины цусан хангамжийн түр зуурын өөрчлөлтүүд, харвалтын үлдэц, даамжрах тархидал, тархины цус тасалдах хөдлөл,

2.4 Гавал тархины гэмтлийн голомтот үлдэц, гэмтлийн гаралтай голомтот өвчний улмаас үүссэн сэтгэцийн үлдэц өөрчлөлтүүд,

2.5 Тархмал хатуурал, түүнтэй төст эмгэг, булчин даамжрах сөнөрөл (миодистрофи, миотони), булчин сулрал,

2.6 Мэдрэлийн тогтолцооны хөгжлийн гажиг.

Гурав. Сэтгэцийн болон зан үйлийн эмгэг

3.1 Оюуны хомсдол, дасан зохицох урвал, тархины органик суурь дээр үүссэн өвөрмөц сэтгэцийн өөрчлөлтүүд, сэтгэл гутралын хам шинж,

3.2 Сэтгэл хөдлөлийн солиорол, мансууруулах ба бусад төрлийн бодис хэрэглэсний улмаас өгсөн хордлогын гаралтай солиорлууд, архины солиорол, органик өвчний улмаас үүссэн сэтгэцийн өөрчлөлтүүд, өтлөлтийн ба өтлөлтийн өмнөх солиорол,

3.3 Архинд донтох өвчин.

Дөрөв. Мэс заслын өвчин

4.1 Мэргэжлийн ажлаа бүрэн хэмжээгээр гүйцэтгэхэд нөлөөлөх өвчнүүд, өвдсөн эрхтний үйл ажиллагаа удаан хугацаагаар алдагдсан тохиолдолд яс, үе мөгөөрсөн эд, том үе, хурууны ясны төрөлхийн болон олдмол архаг өвчин, янз бүрийн гэмтлийн улмаас, хагалгаа хийлгэсний дараах үлдэц, биеийн дутуу хөгжил, гажиг,

4.2 Хөл гар тайрагдсан буюу хөл 5 см-ээс илүү богиносолтой, томоохон үений үйл ажиллагаа хязгаарлагдмал болсон /мэргэжлийн ажлаа гүйцэтгэх боломжгүй/,

4.3 Архаг идээт өвчнүүд /цээжинд хий хурах, цээжний ба хэвлийн хөндийн буглаа, шулуун гэдэсний эдийн үрэвсэл, гэдэсний ба давсагны цоорхой, бусад/,

4.4 Ясны сүрьеэгийн идэвхтэй хэлбэр, түүний үлдэц, бөөр бэлгийн замын сүрьеэ,

4.5 Хураагуур судасны бүх хэлбэрийн бүлэнт үрэвсэл шинээр ажилд орогсод эсрэг заалттай, хуучин ажиллагсдад мэргэжлийн ажлаа гүйцэтгэхэд саад болох тохиолдолд эсрэг заалт гаргаж болно,

4.6 Хэл ярианд илт нөлөөлөх эрүү, хатуу зөөлөн тагнай, хэл уруулын өвчнүүд,

4.7 Улаан хоолойн үйл ажиллагааны алдагдалтай, түүний сорвижилт үлдэгдэл, дахилттай улаан хоолойн төгсгөлийн агшилт,

4.8 Шулуун гэдэс болон давсаг, шээс дамжуулах эрхтний өвчин, шээс баасаа бүрэн барьдаггүй болон шээс баас гарах хоолой үүссэн тохиолдол,

4.9 Шинээр ажилд орогсод бүх төрлийн хорт хавдар эсрэг заалттай, хуучин ажиллагсдад хорт хавдраар өвчлөөд эмчилгээний дараа үр дүн өгсөн, хүндрэл гараагүй тохиолдолд ажилд буцаж орж болно,

4.10 Шинээр ажилд орогсод бүх төрлийн ивэрхий эсрэг заалттай, хуучин ажиллагсдаас ивэрхийтэй өвчтөн байвал бүх төрлийн техник жолооддог, биеийн хүнд хөдөлмөр эрхлэхэд эсрэг заалттай.

Тав. Нүдний өвчин

5.1 Нүдний гажиг хөгжлөөс болсон харах үйл ажиллагааны алдагдал, алимгүйдэл,

- 5.2 Хараанд нөлөөлөх, байнгын нулимс гоожилттой нулимсны сувгийн, салст бүрхүүл, эвэрлэг, солонголог бүрхүүлийн өвчнүүд,
- 5.3 Хараанд нөлөөлөх болрын бүдэгшил, болоргүй нүд,
- 5.4 Хараанд нөлөөлөх судаслаг давхарга, торлог, шиллэг биет, харааны мэдрэлийн өөрчлөлтүүд,
- 5.5 Өнгөний харааны хомсдол-улаан өнгө ялгахгүй, ногоон өнгө ялгахгүй гажгийн А, В, С зэрэг,
- 5.6 Зохицолгүй нүдний даралт ихдэх өвчин тэнцэхгүй. Зохицолтой нүдний даралт ихдэх өвчинтэй бол шинээр ажиллагсдад тэнцэхгүй,
- 5.7 Харааны үйл ажиллагаанд нөлөөлөх нүдний алимны болон зовхины булчингийн саа, саажилт, зовхины буулт, нүдний анивчаа, саат хялар, хам хялар, анишгүйдэл, нүд чичирхийлэх өвчнүүд,
- 5.8 Шөнийн сохор өвчтэй хүн .

Зургаа. Арьс, харшлын өвчин

- 6.1 Хүнд явцтай намарс, арьсны харшилт үрэвсэл /үе үе хурцаддаг болон бүх биеийг хамарсан/,
- 6.2 Тархмал хэлбэрийн арьсны загатнаат өвчин, тархмал арьсны үрэвсэл,
- 6.3 Үе мөчний өөрчлөлт өгсөн хүнд хэлбэрийн хайрст үлд, хавтгай улайц өөрчлөлт,
- 6.4 Арьсны цэврүүт өвчин, Дюрингийн арьсны үрэвсэл,
- 6.5 Арьс ширших харшлын эмгэг,
- 6.6 Шинээр ажилд орж байгаа хүмүүс өнгөний болон халдварт, идээт арьсны өвчтэй байвал уг өвчин эдгэрч халдваргүй болтол нь ажилд авахыг хориглоно.

Долоо. Мэргэжлээс шалтгаалсан өвчин

7.1 Мэргэжлээс шалтгаалсан уушиг тоосжих эмгэг

- 7.1.1 Уушиг тоосжих өвчин,
- 7.1.2 Тоосжилтын ба хордлогын шалтгаант гуурсан хоолойн архаг үрэвсэл,
- 7.1.3 Тоосжилт, харшил, хордлогын шалтгаант багтраа.

7.2 Мэргэжлээс шалтгаалсан хордлогын өвчин

- 7.2.1 Химийн бодисын архаг хордлогын улмаас үүсэх эмгэгүүд,
- 7.2.2 Ароматик бодисуудын хордлого,

- 7.2.3 Цочроогч боогдуулагч бодисын хордлого,
- 7.2.4 Пестицидийн хордлого,
- 7.2.5 Органик хүчлүүд ба түүний нэгдлүүдийн хордлого.

7.3 Мэргэжлээс шалтгаалсан арьс, харшлын өвчин

- 7.3.1 Эм, химийн сэдээгч бодис, будаг, тослох материал, металл, нефтийн бүтээгдэхүүнээс үүссэн,
- 7.3.2 Хэт халуун орчин, нарны илч, хэт хүйтэн, цахилгаан соронзон орны нөлөөлөл, цацраг идэвхит туяатай байнга ажилласнаас үүссэн арьсны өвчнүүд.

7.4 Мэргэжлээс шалтгаалсан нүдний өвчин

- 7.4.1 Мэргэжилтэй холбоотой үүссэн нүдний салстын архаг үрэвсэл, нулимсны хүүдийн архаг үрэвсэл,
- 7.4.2 Мэргэжилтэй холбоотой үүссэн нэг болон хоёр нүдний болорын хатууралын эмгэг,
- 7.4.3 Мэргэжилтэй холбоотой үүссэн харааны мэдрэлийн хатингаршил,
- 7.4.4 Мэргэжилтэй холбоотой үүссэн нүдний эвэрлэг бүрхүүлийн архаг үрэвсэл болон сөнөрлийн эмгэг өөрчлөлтүүд,
- 7.4.5 Мэргэжилтэй холбоотой үүссэн нүдний торовчын эмгэг,
- 7.4.6 Мэргэжилтэй холбоотой үүссэн нүдний дотоод даралт ихсэлт /нүдний шилэнцэрийн эмгэг, нүдний хараа муудах, глаукоми, астигматизм, миопи/.

7.5 Мэргэжлээс шалтгаалсан мэдрэлийн эмгэгүүд

- 7.5.1 Доргионы өвчнүүд /Хэсгийн, ерөнхий, хавсарсан доргионоос үүсэх эмгэг, цахилгаан соронзон талбай, лазер, радио долгионы нөлөөллөөс үүсэх өвчин, нурууны спондилопатия/ остеохондроз, спондилоартроз, нугалмайн жийргэвчний ивэрхийн шалтгаант компрессионноишемический синдром, хүзүү сээр, бүсэлхий хэсгийн радикулопатия/ дээд, доод мөчний мэдрэлийн язгуурын өвдөлт, дарагдлын хам шинж.

7.6 Мэргэжлээс шалтгаалах чих хамар хоолойн өвчин.

- 7.6.1 Шуугианы гаралтай сонсгол бууралт,
- 7.6.2 Дууны эрхтэний эмгэг,
- 7.6.3 Мэргэжлээс шалтгаалсан амьсгалын дээд замын өвчлөл.

7.7 Радио идэвхит бодис болон рентген туяанаас үүссэн туяаны өвчин

7.8 Мэргэжлээс шалтгаалсан мэс заслын өвчин

- 7.8.1 Доод мөч, хэвлий, аарцгийн эрхтний хөх судас өргөсөх өвчин,
- 7.8.2 Тулгуур эрхтний үе мөчний хэлбэр, хөдөлгөөн алдагдах өвчин,
- 7.8.3 Артерийн судасны олдмол нарийсал ба бөглөрөл,
- 7.8.4 Дээд мөчний бичил гэмтэл давтагдсан ачааллаас үүссэн өвчин /үений хүүдийн үрэвсэл, дал мөрний үений холбоосын өвчин, дээд мөчний мэдрэлүүдийн саа, шөрмөс ба уутанцарын үрэвсэл/,
- 7.8.5 Тавхай хавтгайрах эмгэг.

Найм. Хавдрын өвчнүүд

- 8.1 Хорт хавдарын хожуу үе буюу III, IV шат.

Ес. Бие бялдарын хөгжил, чийрэгжүүлэлтийн түвшин тогтоох сорил

- 9.1 Бие бялдарын хөгжил, чийрэгжүүлэлтийн түвшин тогтоох сорилд А-хангалттай сайн, В-хангалттай, С-сайн, D-дунд, F-хангалтгүй гэсэн үнэлгээгээр үнэлэн “F” үнэлгээ авсан тохиолдолд галт тэрэгний ба хөдөлгөөнтэй шууд холбоотой ажилд тэнцэхгүй. Ажилтны бие бялдарын хөгжил чийрэгжүүлэлтийн түвшинг дээшлүүлэхийн тулд бие бялдарын чанарын түвшинг сайжруулах дасгал хөдөлгөөнүүдийг хувь хүний биеийн онцлогт тохируулан уян хатан, хурд, тэсвэр, авхаалж самбаа, тэнцвэрийн чанаруудаас сонгон дасгал хөдөлгөөнийг заана.

---oOo---

Зам тээврийн сайдын 2025 оны
... дүгээр сарын .. –ны өдрийн ...
тоот тушаалын хоёрдугаар хавсралт

**Галт тэрэгний болон сэлгээний хөдөлгөөнтэй шууд
холбоотой ажилд харшлах өвчний жагсаалт**

Нэг. Дотрын өвчнүүд

№	Өвчний бүлэг	Өвчний нэр	Шинээр ажилд орсон	Хуучин ажиллагсад
Зүрхний үйл ажиллагааны дутмагшил				
1	Төрөлхийн гажгууд	<p>A. Зүрхний архаг дутагдлын” В“үе шат</p> <p>B. Зүрхний архаг дутагдал С үе шат</p> <p>C. Уушгины артерийн даралт ихсэлт /PASP-30 мм муб-аас дээш/</p> <p>D. Төрлөхийн гажиг засах мэс заслын дараах байдал</p>	Бүх бүлэгт тэнцэхгүй	<p>A.Эмчилгээний дараа тэнцэнэ.</p> <p>B.C.Бүх бүлэгт тэнцэхгүй.</p> <p>D. Эмчилгээний дараа тэнцэнэ.</p>
2	Олдмол гажгууд	<p>A. Зүрхний архаг дутагдлын” В“үе шат</p> <p>B. Хавхлаг засах хагалгааны дараах байдалтай</p>	Бүх бүлэгт тэнцэхгүй	<p>A. Бүх бүлэгт тэнцэхгүй.</p> <p>B. Эмчилгээний дараа !</p>
Артерийн даралт ихсэх өвчин				
3	Артерийн	A. Артерийн даралт		

	даралт ихдэх өвчин	ихсэх өвчин 1-р үе шат, эрсдэлгүй /24 цагийн Артерийн даралт хэмжих шинжилгээгээр батлагдсан/ В. Артерийн даралт ихсэх өвчин 2-р үе шат, эрсдэл 1-3 С. Артерийн даралт ихсэх өвчин 3-р зэрэг эрсдэл өндөр	Бүх бүлэгт тэнцэхгүй	А. Эмийн эмчилгээнд даралт тогтвортой бол тэнцэнэ В. Эмийн эмчилгээнд даралт тогтворжиж, эрсдлийн хүчин зүйл буурсан бол тэнцэнэ. С. Аль ч бүлэгт тэнцэхгүй
Зүрхний цус хомсрох өвчин				
4	Тогтвортой цээжний бах	Үйл ажиллагааны алдагдал 2-р зэрэг /Ачаалалтай ЭКГ сөрөг/	Бүх бүлэгт тэнцэхгүй	Бүх бүлэгт тэнцэхгүй
5	Тогтворгүй цээжний бах	Ачаалалтай ЭКГ эерэг, ТСДО батлагдсан	Бүх бүлэгт тэнцэхгүй	Бүх бүлэгт тэнцэхгүй
6	Зүрхний шигдээс	А. ТСДЭ хийлгэсэн, эдгэрсэн / Зүрхний ЭХОКГд сегментийн агшилт жигд/, эрсдэлийн хүчин зүйл бага В. ТСДЭ хийлгэсэн ч дахих хандлагатай, эрсдэлт хүчин зүйлтэй, олон судасны өөрчлөлттэй	Бүх бүлэгт тэнцэхгүй	А. Бүх бүлэгт тэнцэнэ. В. Бүх бүлэгт тэнцэхгүй.
7	Ишемиийн кардиомиопати	Зүрхний архаг дутагдлын” В“үе	Бүх бүлэгт тэнцэхгүй	Бүх бүлэгт тэнцэхгүй.

8	Шигдээсийн дараах зүрхний хатуурал Энэ илүү	Зүрхний архаг дутагдлын” В үе	Бүх бүлэгт тэнцэхгүй	Бүх бүлэгт тэнцэхгүй.
Зүрхний хэм алдагдал				
9	Хүнд хэлбэрийн түр зуурын муужралт өгдөг хэм алдагдлууд	А. Пароксизмаль тахикардия В. Тосгуур ховдлын хориг С. Синусын зангилааны сулралын хам шинж D. Олон давтамжтай ховдол, тосгуурын экстрасистол /Холтер ЭКГ/ E. Тосгуурын жирвэгнээ байнгын, түр зуурын /Холтер экг/	Бүх бүлэгт тэнцэхгүй	Бүх бүлэгт тэнцэхгүй.
Зүрхний үрэвсэлт өвчнүүд				
10	Шүүдэст ба наалдаст перикардит	Зүрхний архаг дутагдлын” В“үе	Бүх бүлэгт тэнцэхгүй	Бүх бүлэгт тэнцэхгүй
11	Миокардит	Зүрхний архаг дутагдлын” В“үе	Бүх бүлэгт тэнцэхгүй	Бүх бүлэгт тэнцэхгүй
12	Халдварт эндокардит	Зүрхний архаг дутагдлын” В“үе	Бүх бүлэгт тэнцэхгүй	Бүх бүлэгт тэнцэхгүй
13	Тэлэгдлийн кардиомиопати	Зүрхний архаг дутагдлын” В“үе	Бүх бүлэгт тэнцэхгүй.	Бүх бүлэгт тэнцэхгүй
14	Зузаарлын кардиомиопати	Зүрхний архаг дутагдлын” В“үе	Бүх бүлэгт тэнцэхгүй	Бүх бүлэгт тэнцэхгүй

Судасны өвчин				
15	Гол судасны цүлхэн	Хэмжээ Ао asc-3.6 мм дээш ЭХО-КГ, Гол судасны КТГ	Бүх бүлэгт тэнцэхгүй	Бүх бүлэгт тэнцэхгүй
16	Захын судасны эмгэг	Гүний судасны эмгэг нь босох суух өргөх түлхэх зэрэг ажил хөдөлмөртэй холбоотой үйл ажиллагааны алдагдал үүсгэх	Бүх бүлэгт тэнцэхгүй	Бүх бүлэгт тэнцэхгүй
Холбогч эдийн өвчнүүд				
17	Чонон яр	Сэдрэл багатай өвчний хөнгөн зэрэг	Бүх бүлэгт тэнцэхгүй	Бүх бүлэгт тэнцэнэ
18	Хэрх төст артрит	Сэдрэл багатай өвчний хөнгөн зэрэг	Бүх бүлэгт тэнцэхгүй	Бүх бүлэгт тэнцэнэ
19	Васкулит	Сэдрэл багатай өвчний хөнгөн зэрэг	Бүх бүлэгт тэнцэхгүй	Бүх бүлэгт тэнцэнэ
20	Склеродерми	Сэдрэл багатай өвчний хөнгөн зэрэг	Бүх бүлэгт тэнцэхгүй	Бүх бүлэгт тэнцэнэ
21	Зангилаат периартрит	Сэдрэл багатай өвчний хөнгөн зэрэг	Бүх бүлэгт тэнцэхгүй	Бүх бүлэгт тэнцэнэ
22	Дерматомиозит	Сэдрэл багатай өвчний хөнгөн зэрэг	Бүх бүлэгт тэнцэхгүй	Бүх бүлэгт тэнцэнэ
Уушигны өвчин				
23	Гуурсан хоолойн архаг үрэвсэл	Байнгын сэдрэлгүй зүрх, болон амьсгалын дутагдалгүй	Бүх бүлэгт тэнцэхгүй	Бүх бүлэгт тэнцэнэ
24	Уушиг тэлэгдэх	Байнгын сэдрэлгүй зүрх, болон амьсгалын дутагдалгүй	Бүх бүлэгт тэнцэхгүй	Бүх бүлэгт тэнцэнэ
25	Гуурсан хоолой тэлэгдэх	А.амьсгалын дутагдалгүй Б.амьсгалын дутагдалтай	Бүх бүлэгт тэнцэхгүй	А.Бүх бүлэгт тэнцэнэ Б.Бүх бүлэгт тэнцэхгүй
26	Гуурсан хоолойн	Амьсгалын дутагдалгүй	Бүх бүлэгт тэнцэхгүй	Ажлын байр нь уг өвчнийг сэдрээх хүчин

	багтраа	хөнгөн хэлбэрийн багтраа		зүйлгүй нөхцөлд бүх бүлэгт тэнцэнэ
27	Уушиг сорвижих	Амьсгалын үйл ажиллагааны дутагдал илрээгүй уушигны фиброз	Бүх бүлэгт тэнцэхгүй	2-р бүлгээс бусад бүлэгт тэнцэхгүй
28	Уушигны сүрьеэ	Эмийн эмчилгээнд бүрэн эдгэрсэн, амьсгалын дутагдалгүй	Бүх бүлэгт тэнцэнэ.	Бүх бүлэгт тэнцэнэ
Хоол боловсруулах замын эмгэг				
29	Элэгний хатуурал	А.Чайльд Пью-“А” Б.Чайльд Пью-“В”	А.1,2,5-р бүлэгт тэнцэхгүй. Б.Бүх бүлэгт тэнцэхгүй	Бүх бүлэгт тэнцэнэ.
30	Элэгний архаг үрэвсэл	А.Үйл ажиллагааны алдагдалгүй Б.Үйл ажиллагааны алдагдалтай	А.1,2,5-р бүлэг тэнцэхгүй Б.бүх бүлэгт тэнцэхгүй	А.Бүх бүлэгт тэнцэнэ Б.Бүх бүлэгт тэнцэхгүй
31	Цөсний сувгийн эмгэг	А.сэдрэл багатай, хөнгөн шат Б.ойрхон сэдэрдэг, үйл ажиллагааны алдагдалтай	А.1,2,5-р бүлэг тэнцэхгүй Б.бүх бүлэгт тэнцэхгүй	А.Бүх бүлэгт тэнцэнэ Б.Бүх бүлэгт тэнцэхгүй
32	Нойр булчирхайн эмгэг	А.сэдрэл багатай, хөнгөн шат Б.Ойрхон сэдэрдэг, үйл ажиллагааны алдагдалтай	А.1,2,5-р бүлэг тэнцэхгүй Б.бүх бүлэгт тэнцэхгүй	А.Бүх бүлэгт тэнцэнэ Б.Бүх бүлэгт тэнцэхгүй
33	Порфирин	А.Сэдрэл багатай, хөнгөн шат Б.Ойрхон сэдэрдэг, үйл ажиллагааны алдагдалтай	А.1,2,5-р бүлэг тэнцэхгүй Б.бүх бүлэгт тэнцэхгүй	А.Бүх бүлэгт тэнцэнэ Б.Бүх бүлэгт тэнцэхгүй
34	Ходоод 12 хуруу гэдэсний шархлаа	А.Сэдрэл багатай, хөнгөн шат Б.Ойрхон сэдэрдэг, үйл ажиллагааны алдагдалтай	А.1,2,5-р бүлэг тэнцэхгүй Б.бүх бүлэгт тэнцэхгүй	А.Бүх бүлэгт тэнцэнэ Б.Бүх бүлэгт тэнцэхгүй
35	Кроны өвчин	А.Сэдрэл багатай, хөнгөн	А.1,2,5-р бүлэг	А.Бүх бүлэгт тэнцэнэ

		шат Б.Ойрхон сэдэрдэг, үйл ажиллагааны алдагдалтай	тэнцэхгүй Б.бүх бүлэгт тэнцэхгүй	Б.Бүх бүлэгт тэнцэхгүй
36	Гэдэсний шимэгдүүлэх үйл ажиллагааны алдагдал, дисбактериоз	А.Сэдрэл багатай, хөнгөн шат Б.Ойрхон сэдэрдэг, үйл ажиллагааны алдагдалтай	А.1,2,5-р бүлэг тэнцэхгүй Б.бүх бүлэгт тэнцэхгүй	А.Бүх бүлэгт тэнцэнэ Б.Бүх бүлэгт тэнцэхгүй
Бөөрний архаг өвчнүүд				
37	Пиелонефрит	А.Архаг дутагдалгүй Б.Архаг дутагдал 1,2-р шат	А.Бүх бүлэгт тэнцэнэ Б.Бүх бүлэгт тэнцэхгүй	А.Бүх бүлэгт тэнцэнэ. Б.Бүх бүлэгт тэнцэхгүй
38	Гломерулонефр ит	А.Даралт ихсэлтээс бусад хэлбэр, архаг дутагдалгүй Б.Архаг дутагдалтай	Бүх бүлэгт тэнцэхгүй	А.Бүх бүлэгт тэнцэнэ. Б.Бүх бүлэгт тэнцэхгүй
39	Амилойдоз	А.Архаг дутагдалгүй Б.Архаг дутагдлын 1,2-р шат	Бүх бүлэгт тэнцэхгүй	А.Бүх бүлэгт тэнцэнэ. Б.Бүх бүлэгт тэнцэхгүй
Дотоод шүүрлийн эмгэгүүд				
40	Чихрийн шижин 1,2-р хэлбэр	А.Ээнэгшилтэй Б.Ээнэгшил алдагдсан	А.Бүх бүлэгт тэнцэнэ Б.Бүх бүлэгт тэнцэхгүй	А.Бүх бүлэгт тэнцэнэ. Б.Бүх бүлэгт тэнцэхгүй
41	Хордлогот бахуу	А.Ээнэгшилтэй, хөнгөн зэрэг Б.Ээнэгшил алдсан	А.Бүх бүлэгт тэнцэнэ Б.Бүх бүлэгт тэнцэхгүй	А.Бүх бүлэгт тэнцэнэ. Б.Бүх бүлэгт тэнцэхгүй
42	Бамбайн дутагдал	А.Эмийн эмчилгээнд ээнэгшилтэй Б.Хүндрэл илэрсэн	А.Бүх бүлэгт тэнцэнэ Б.Бүх бүлэгт тэнцэхгүй	А.Бүх бүлэгт тэнцэнэ. Б.Бүх бүлэгт тэнцэхгүй
43	Бөөрний дээд булчирхайн болон бусад эмгэг		Бүх бүлэгт тэнцэхгүй	Бүх бүлэгт тэнцэхгүй

Цусны эмгэг				
44	Хүнд хэлбэрийн цус багадалт, цусны хортой хоргүй хавдарууд		Бүх бүлэгт тэнцэхгүй	Бүх бүлэгт тэнцэхгүй

Хоёр. Мэдрэлийн өвчнүүд

№	Өвчний нэр	Шинээр ажилд орогсод	Хуучин ажиллагсад
1	Тархины харвалтын (инсульт) уршиг үлдэц байдал, судасны мэс заслын урхаг /мальформаци, аневризмын хагалгааны дараахи байдал/ хөдөлгөөн-мэдрэхүйн хөнгөн зэргийн талласан саатай	Бүх бүлэгт тэнцэхгүй	Бүх бүлэгт тэнцэхгүй
2	Нугасны харвалтын (миелоишеми, гематомиели) үлдэц байдал /доод мөчний хөдөлгөөн-мэдрэхүйн хөнгөн хос саа/	Бүх бүлэгт тэнцэхгүй	Бүх бүлэгт тэнцэхгүй
3	Тархины бүрхэвч, тархины эдийн үрэвслийн урхаг үлдэц (менингит, энцефалит, менингоэнцефалит)	Бүх бүлэгт тэнцэхгүй	Бүх бүлэгт тэнцэхгүй
4	Тархмал хатуурал, түүнтэй төст эмгэг /Сэдрэх явцтай, хөнгөн зэргийн саа, тэнцвэрийн өөрчлөлт/	Бүх бүлэгт тэнцэхгүй	Бүх бүлэгт тэнцэхгүй
5	Булчин даамжрах сөнөрөл (миодистрофи, миотони)	Бүх бүлэгт тэнцэхгүй	Бүх бүлэгт тэнцэхгүй
6	Булчин сулрал (миастени)	Бүх бүлэгт тэнцэхгүй	Бүх бүлэгт тэнцэхгүй
7	Паркинсоны өвчин, паркинсонизм /Өвчний эхлэл үе, салганалтай/	Бүх бүлэгт тэнцэхгүй	Бүх бүлэгт тэнцэхгүй
8	Нугас бага тархи, бага тархины тэнцвэргүйдэл (спиноцеребральный, церебральный атакси)	Бүх бүлэгт тэнцэхгүй	Бүх бүлэгт тэнцэхгүй
9	Тархи, нугасны гэмтлийн дараах урхаг байдал /тархи эмгэгшлийн хам шинж, толгойн	Бүх бүлэгт тэнцэхгүй	Бүх бүлэгт тэнцэхгүй

	архаг өвдөлт, тархмал бичил органик шинж, зан төрх, хэл ярианы өөрчлөлт, танин мэдэхүйн бууралт/	Бүх бүлэгт тэнцэхгүй	Бүх бүлэгт тэнцэхгүй
10	Тархи, нугасны хавдрын мэс заслын дараах үлдэц байдал /мэс заслын дараах үлдэц, хөнгөн зэргийн өөрчлөлт/	Бүх бүлэгт тэнцэхгүй	Бүх бүлэгт тэнцэхгүй
11	Мөрний сүлжээний саа (мөрний дээд, доод плексопати) /Мөр бугалга, гарын нэг талын хатангирт саатай/	Бүх бүлэгт тэнцэхгүй	1-р бүлэгт тэнцэхгүй. 3.1 Галт тэрэгний найруулагч, туслах найруулагч, ивүүрчинд тэнцэхгүй. 3.3 Кранчин, гагнуурчин, засварчинд тэнцэхгүй 4.2 Вагоны үйлчлэгчид тэнцэхгүй 5.1 Замчин, сэв хайгчийн оператор, сэв хайгчийн операторын туслах, засварын машин механизмын инженер-механикч, машинч, замын гүүрийн мастер тэнцэхгүй. 6.1 Шугамын монтёр тэнцэхгүй
12	Дээд мөчний ганц мэдрүүлийн саа (мононевропати) /Сарвуу, хурууны саа/	Бүх бүлэгт тэнцэхгүй	1-р бүлэгт тэнцэхгүй. 3.1 Галт тэрэгний найруулагч, туслах найруулагч, ивүүрчинд тэнцэхгүй. 5.1 Замчин, сэв хайгчийн оператор, сэв хайгчийн операторын туслах, засварын машин механизмын инженер-механикч, машинч, замын гүүрийн мастер тэнцэхгүй. 6.1 Шугамын монтёр тэнцэхгүй
13	Бүсэлхий ууцны сүлжээний саа (бүсэлхийн плексопати) /нэг хөлийн саа, дунд зэргийн/	Бүх бүлэгт тэнцэхгүй	1-р бүлэгт тэнцэхгүй. 3.1 Галт тэрэгний найруулагч, туслах найруулагч, ивүүрчинд тэнцэхгүй. 5.1 Замчин, сэв хайгчийн оператор, сэв хайгчийн операторын туслах, засварын машин механизмын инженер-механикч, машинч, замын гүүрийн мастер тэнцэхгүй. 6.1 Шугамын монтёр тэнцэхгүй

14	Доод мөчний ганц мэдрүүлийн саа (мононевропати) /Нэг талын тавхайн саа/	Бүх бүлэгт тэнцэхгүй	1-р бүлэгт тэнцэхгүй. 3.1 Галт тэрэгний найруулагч, туслах найруулагч, ивүүрчинд тэнцэхгүй. 5.1 Замчин, сэв хайгчийн оператор, сэв хайгчийн операторын туслах, засварын машин механизмын инженер-механикч, машинч, замын гүүрийн мастер тэнцэхгүй. 6.1 Шугамын монтёр тэнцэхгүй
